

Алтан Рио Минералс (f. Шар Төсөл)

Улс:	Монгол
Төслийн дугаар:	43410
Бизнесийн салбар:	Байгалийн нөөц
Төрийн/Хувийн:	Хувийн
Хүрээлэн буй орчны зэрэглэл:	В
Захирлуудын Зөвлөлийн хурлын өдөр:	2013 оны 12-р сарын 17
Статус:	Гарын үсэг зурагдсан
Төслийн Хураангуй Баримт Бичиг(ТХББ) нийтлэгдсэн огноо:	2014 оны 5-р сарын 13

Төслийн танилцуулга

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк(ЕСБХБ)-ны зүгээс 10 сая канад доллар хүртэлх хэмжээний шууд хөрөнгө оруулалтыг Алтан Рио Минералз Лимитед (цаашид “Компани” гэх) компанид хийхээр шийдвэрлэлээ. Санал болгож буй хөрөнгө оруулалтын зорилго нь Монгол улсад алтны хайгуул хийж буй компанид дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Тус Компани нь 2007 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Канад улсын Ванкувер хотод төв оффис нь байрладаг ба Компанийн хувьцаа Торонтогийн Хөрөнгийн Бирж (ТХБ)-д арилжаалагдаж байна.

Шилжилтийн үйл явцад үзүүлэх нөлөөлөл

Энэхүү төслийн шилжилтийн үйл явцад үзүүлэх нөлөөллийн гол хүчин зүйл нь байгаль орчны удирдлагын ISO 14001 стандарт болон аюулгүй байдлын удирдлагын OHSAS 18001 стандартуудыг нэвтрүүлэх, мөн Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгыг мөрдлөг болгох замаар ил тод байдал, бизнес, хүрээлэн буй орчны ёс зүйн өндөр стандартуудыг тогтоох явдал болно.

Энэхүү хөрөнгө оруулалт нь Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдал ба Тогтвортой байдлын өндөр стандартуудыг нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ Монгол улсад хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагчдад сайн туршлага, үлгэр дуурайлал болох юм.

Харилцагч

Алтан Рио Минералз Лимитед.

ЕСБХБ-ны Санхүүжилт

ЕСБХБ нь тус Компанийн Монгол улсад хийх хайгуул өрөмдлөгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийхээр шийдвэрлэлээ. Шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 10 сая хүртэлх канад доллар байна.

Төслийн өртөг

10 сая хүртэлх Канад доллар.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Б Зэрэглэл. Тус Банкны байгаль орчны болон нийгмийн мэргэжилтнүүд тус Компанитай Монгол улсад болон Лондон хотод уулзсан. Нарийвчилсан судалгааг хөндлөнгийн бие даасан зөвлөх хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны явцад Компанийн удирдлагатай хэд хэдэн удаа уулзаж, Хавчуу, Чандмань Ёл зэрэг тусгай зөвшөөрөлтэй газруудад очиж танилцлаа. Өнөөг хүртэл хийгдсэн хайгуулын ажил болон 2014 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын хувьд Байгаль орчин буюу Нийгэмд үзүүлэх мэдэгдэхүйц нөлөөлөл илрээгүй. Байгаль орчны болон Нийгмийн Арга хэмжээний Төлөвлөгөө (цаашид “БОНАХТ”)-г Компанитай хамтран бэлтгэсэн. БОНАХТ-нд тусгагдсаны дагуу Компанид тохирсон дараахь менежментийн системийг нэвтрүүлнэ. Үүнд: (i) Байгаль орчны ISO 14001 стандарт болон (ii) Аюулгүй байдлын OHSAS 18001 стандарт. Түүнчлэн, тус Компани Банкны шаардлагад нийцүүлэн Техникийн Урьдчилсан Үнэлгээ/Техникийн Үнэлгээний үе шатанд нэмэлт ажлууд хийх шаардлага гарч болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн ба Компани хайгуулын ажлын үйл явцад эдгээр болон бусад асуудлуудаар Банктай зөвшилцөн нягт хамтран ажиллахаар харилцан тохиролцлоо.

Техникийн хамтын ажиллагаа

Байхгүй.

Компанитай холбоо барих

Altan Rio Minerals Limited
800 – 1199 West Hastings St.
Vancouver, BC
Canada, V6E 3T5
Phone: +1 604 639 5899

Бизнес хамтын ажиллагаа

Бизнесийн боломжууд болон худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар харилцагч компанитай холбогдоно уу.

Ерөнхий лавлагаа авах

ЕСБХБ-наас төсөлтэй холбоотой лавлагаа (ажил үйлчилгээ худалдаж авахтай холбоогүй) авах хаяг:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Олон Нийтэд Мэдээлэх Журам (ОНМЖ)

ОНМЖ нь ЕСБХБ-аас өөрийн баримталж буй стратеги, журмууд болон явуулж буй үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх зорилгоор мэдээллийг хамааралтай этгээдэд хэрхэн түгээх, тэдэнтэй зөвлөлдөх үйл ажиллагааг зохицуулна. ОНМЖ-ын баримт бичгийг дараахь хаягаар орж үзнэ үү.

<http://www.ebrd.com/about/policies/pip/index.htm>

Санал Гомдлыг хүлээн авах/шийдвэрлэх журам (СГЖ)

ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдийн үйл ажиллагаанаас хэн нэгэнд ямарваа хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй талаар нэг буюу түүнээс олон тооны хувь хүн, албан байгууллагын зүгээс мэдүүлсэн гомдлыг хараат бус байдлаар нэг бүрчлэн авч үзэх, хянах боломжийг олгох үүднээс СГЖ-г бий болгосон. СГЖ-ыг Англи хэл дээр www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf, холбоосоор, Орос хэл дээр <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesr.pdf> холбоосоор орж авна уу.

СГЖ-ын дагуу аливаа санал гомдлыг ЕСБХБ-ны санхүүжилт хийгдсэнээс хойш 12 сарын хугацаанд хүлээн авна. Санал гомдлоо ямар хугацаанд хэрхэн ирүүлэх талаар тодруулах, туслалцаа авахыг хүсвэл pcm@ebrd.com хаягаар СГБТ-ны ажилтантай холбогдох буюу ЕСБХБ-ны төлөөлөгчийн газарт хандана уу.

Төслийн хураангуй баримт бичгүүд(ТХББ) нь ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөлд танилцуулахаас өмнө боловсруулагдсан. Энэхүү баримт бичгийг гаргаснаас хойш уг Төсөлд өөрчлөлт гарсан байж болох бөгөөд уг баримт бичиг нь Банкны албан ёсны баримт бичигт тооцогдохгүй болно.

Хамгийн сүүлд 2014 оны 5-р сарын 13-ны өдөр шинэчлэв.